



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

106 дугаар байр, Найрамдалын гудамж 1,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442878, 70442891

Цахим шуудан:emg@bayankhongor.moh.gov.mn

2023. 10. 31 № 10-16-02/074/19

Г ЦЭСДА ХХК-НИЙ ЗАХИРАЛ
Ц.ОРХОНТАМИР ТАНД

Г Барилгын зурагт эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

ЦЭСДА ХХК-с ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багт баригдах Нийгмийн даатгалын хэлтсийн оффисын барилгын ажлын зурагт Эрүүл ахуй тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/07 дугаар удирдамж болон холбогдох стандарт, норм дүрэм, журмын хэрэгжилтийг ханглулахаар 2023 оны 10 дугаар сарын 27-31-ны өдрүүдэд эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт хийлээ.

Барилга байгууламжийн зориулалт:

Барилгын зургийг "ЦЭСДА" ХХК гүйцэтгэсэн. Шифр: ЦЭ-11-06-08-200/23

Баянхонгор аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/753 тоот захирамжтай, 2689 метр квадрат хэмжээтэй, 6409007872 нэгж талбарын дугаартай, төрийн захирагааны байгууллага зориулалтаар олгосон байна.

Уг барилга байгууламж нь ногоон байгууламж, авто машины зам талбайтай, тэнхлэгээрээ 15m*18m хэмжээтэй, зоорьтой, 3 давхар барилга. Зоорийн давхарт архив, агуулах, узелийн өрөөнүүд, гараж. Нэгдүгээр давхарт хэлтсийн даргын өрөө, угтах үйлчилгээний хэсэг, харуул хамгаалалтын өрөө, архивын өрөө, нэг цэгийн үйлчилгээний танхим, иргэдэд үйлчлэх вип өрөө, эрэгтэй, эмэгтэй, ХБИ ариун цэврийн өрөө, ажлын өрөө. Хоёрдугаар давхарт Эрэгтэй, эмэгтэй, ХБИ ариун цэврийн өрөө, цайны өрөө, уулзалт амралтын танхим, тасгийн даргын өрөө, байцаагч нарын өрөө, тэтгэврийн байцаагчийн өрөө, санхүү нягтлангийн өрөө, бичиг хэргийн өрөө. Гуравдугаар давхарт Эрэгтэй, эмэгтэй, ХБИ ариун цэврийн өрөө, даргын өрөө (амралтын өрөө, ариун цэврийн өрөө), нарийн бичгийн өрөө, ерөнхий нягтлангийн өрөө, хурлын танхим төлөвлөсөн.

Ус хангамж, бохир ус зайлцуулалтын байдал: Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдох "Чандмань-Баянхонгор" ХК-ний 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/2023 дугаартай техникийн нөхцөлтэй. Хэрэгцээний халуун хүйтэн усны төвлөрсөн системд холбогдоно. Сондгой давхрын бохир усны босоо шугамд ревиз төлөвлөсөн. Угаагуур дээр аяган болон усан хаалт бүхий сифон хийхээр төлөвлөсөн.

Дулаан хангамж, агаар сэлгэлтийн байдал: "Хөвших од" ХХК-ний 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дулаанаар хангах техникийн нөхцөлтэй. Халаах хэрэгсэлд ширмэн радиатор төлөвлөсөн.

Ердийн болон механик агааржуулалтын системтэй. Хурлын зааланд цэвэр агаарыг нөхөн өгөх систем төлөвлөсөн.

Инженер геологийн судалгаа: Инженер геологийн судалгааны ажлыг "Топ гео техник" ХХК гүйцэтгэсэн. Хөрсний ус Зм гүнд илэрсэн. Элсэн чигжээстэй хайрган ул хөрстэй.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

Барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгэхэд эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй.

Цаашид авах арга хэмжээ:

1. Цэвэр усны шугамд цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсний дараа, хангагч байгууллагын зөвшөөрөл авч төвийн шугамд холбох, техникийн туршилт хийх,

2. Ариун цэврийн өрөөний шалны төвшин бусад өрөөний шалнаас -2,5-3 см доошоо сууж, хаягдал усны трамп хийхээр төлөвлөн, гүйцэтгэх,

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гаргах эрхийн хүрээнд:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана./, 14.2 дахь /Улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг дээд шатны улсын байцаагч хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвэл гомдоо шүүхэд гаргаж болно./

ЭРҮҮЛ АХҮЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ц.УРАНГОО
10-16-02/074

ХҮЛЭЭН АВСАН: 22-563 ATX6037
АРХИТЕКТОР Т.БИЛГҮҮНБОЛД
БИЛГҮҮНБОЛД Т.БИЛГҮҮНБОЛД
МЭРГЭШСЭН АРХИТЕКТОР
МАЕА
2022-2025

